



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 286

Улаанбаатар хот

“Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны  
зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”-ийг  
шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.5, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”-ийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Тогтоолын 1-д заасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 246 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн 12 дугаар хавсралтын 3, 10, 11-д заасан шалгуур үзүүлэлтийг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор хангаж ажиллахыг нийт хадгаламж, зээлийн хоршоодод үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

1518000652



## ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

### НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэхүү зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос хадгаламж, зээлийн хоршоо (цаашид “ХЗХ” гэх)-ны санхүүгийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт (цаашид “шалгуур үзүүлэлт” гэх)-ийг тогтоох, түүний хэрэгжилтэд хяналт тавихад оршино.

1.2.ХЗХ өөрийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг дараах үндсэн дөрвөн бүлэг үзүүлэлтийн дагуу тооцож, мөрдлөг болгон ажиллана.

1.2.1.Хөрөнгийн чанарын, хамгаалалтын үзүүлэлт;

1.2.2.Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлт;

1.2.3.Өгөөж, зардлын хувь хэмжээний үзүүлэлт;

1.2.4.Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт.

1.3.ХЗХ энэхүү шалгуур үзүүлэлтийн 1.2-т заасан үзүүлэлтүүдийг үнэн зөв тооцож, түүний өөрчлөлтөд нөлөөлсөн хүчин зүйл, шалтгааныг тогтоон үнэлэлт, дүгнэлт өгөх замаар өөрийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тооцох, түүнээс сэргийлэх арга хэмжээг авна.

1.4.ХЗХ өөрийн үйл ажиллагаатай холбоотой бүх төрлийн эрсдэлийг үнэлэх, хяналт тавих, удирдах зорилгоор нэмэлт журмыг дотооддоо боловсруулан мөрдүүлж болно. Тэдгээр нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль болон холбогдох бусад хууль, журамтай нийцсэн байна.

1.5.Хянан шалгагч ХЗХ-ны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг хянан, холбогдох аргачлалын дагуу үнэлгээ хийж хууль, журамд заасан шаардлагатай арга хэмжээг авна.

### ХОЁР.ХӨРӨНГИЙН ЧАНАР, ХАМГААЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ

2.1.ХЗХ-ны актив хөрөнгийг холбогдох журмын дагуу ангилж, эрсдэлийн сан байгуулна.

2.2.Зээл, өмчлөх бусад хөрөнгө болон бусад активтай холбоотой гэрээ, хэлцлийн дагуу үүрэг хүлээсэн этгээд үндсэн зээл, түүний хүүгийн төлбөрийг бүхэлд нь болон хэсэгчлэн буцаан төлөх чадваргүй болж болзошгүй үндэслэл бүхий баримт (зээлийн гэрээний хугацаа дууссан, барьцаа хөрөнгийн чанар муудсан, зах зээлийн үнэ буурсан, байгалийн болон гэнэтийн эрсдэл учирсан зэрэг)-аар тогтоогдвол ХЗХ эрсдэлийн санг зардлаар байгуулна.

2.3.ХЗХ-ны хэвийн зээл, авлагыг санхүүгийн тайлан тэнцэлд анх тусгаснаас хойш эрсдэлийн сан байгуулсан тохиолдолд санхүүгийн тайланд холбогдох үндэслэл, шийдвэр, баримт материалыг хавсаргаж Хороонд хүргүүлнэ.

2.4.ХЗХ-ны чанаргүй зээлийн үлдэгдлийг нийт зээлд харьцуулж тооцно.

*Тооцоолол:* а-тайлант хугацааны эцэс дэх чанаргүй зээлийн дүн

б-тайлант хугацааны эцэс дэх нийт зээлийн дүн

$$\frac{a}{b} \times 100$$

2.5.ХЗХ-ны нэг гишүүн болон нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон нийт зээлийн дүнг өөрийн хөрөнгөд харьцуулж тооцно.

*Тооцоолол:* а-нэг гишүүнд олгосон зээлийн дүн

б-тайлант хугацааны эцэс дэх ХЗХ-ны нийт өөрийн хөрөнгийн дүн

$$\frac{a}{b} \times 100$$

*Тооцоолол:*  $a_1, a_2, \dots, a_n$  - нэгдмэл сонирхолтой этгээдүүдэд олгосон зээлийн дүнгүүд

б-тайлант хугацааны эцэс дэх ХЗХ-ны нийт өөрийн хөрөнгийн дүн

$$\frac{(a_1 + a_2 + \dots + a_n)}{b} \times 100$$

## ГУРАВ.ҮР АШИГТАЙ САНХҮҮГИЙН БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ

### 3.1.Хөрөнгө

3.1.1.Нийт зээлийн үлдэгдлээс эрсдэлийн санг хассан дүнг нийт хөрөнгөд харьцуулна.

*Тооцоолол:* а-тайлант хугацааны эцэс дэх нийт зээлийн дүн

б-тайлант хугацааны эцэс дэх зээлийн эрсдэлийн сангийн дүн

с-тайлант хугацааны эцэс дэх нийт хөрөнгийн дүн

$$\frac{a - b}{c} \times 100$$

3.1.2.ХЗХ-ны цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийг нийт хөрөнгөд харьцуулж тооцоолно.

*Тооцоолол:* а-тайлант хугацааны эцэс дэх цэвэр үндсэн хөрөнгийн дүн

б-тайлант хугацааны эцэс дэх нийт хөрөнгийн дүн

$$\frac{a}{b} \times 100$$

### 3.2.Эх үүсвэр

3.2.1.Гишүүдээс хадгалуулсан мөнгөн хадгаламжийн нийт дүн нь нийт хөрөнгөд харьцуулна.

*Тооцоолол:* а-тайлант хугацааны эцэс дэх нийт хадгаламжийн дүн

б-тайлант хугацааны эцэс дэх нийт хөрөнгийн дүн

$$\frac{a}{b} \times 100$$

3.2.2.ХЗХ-ны банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, төсөл, хөтөлбөрийн зээлийн дүнг нийт хөрөнгөд харьцуулна.

*Тооцоолол:* а-тайлант хугацааны эцэс дэх гаднаас авсан зээлийн дүн  
b-тайлант хугацааны эцэс дэх нийт хөрөнгийн дүн

$$\frac{a}{b} \times 100$$

3.2.3. Нэг гишүүний оруулж болох хувь хөрөнгийг нийт хувь хөрөнгийн дүнд харьцуулж тооцно.

*Тооцоолол:* а-1 гишүүний оруулсан хувь хөрөнгийн дүн  
b- тайлант хугацааны эцэс дэх ХЗХ-ны нийт хувь хөрөнгийн дүн

$$\frac{a}{b} \times 100$$

3.2.4. Хоршоологчдын өмч нь нөөцийн сан, хадгаламж хамгаалалтын сан, тогтворжилтын сан, нийгмийн хөгжлийн сан болон бусад сан, хуримтлагдсан орлого (алдагдал)-ын нийлбэрээс бүрдэх бөгөөд нийт хөрөнгөд харьцуулж тооцно.

*Тооцоолол:* а-тайлант хугацааны эцэс дэх хоршоологчдын өмчийн дүн  
b-тайлант хугацааны эцэс дэх нийт хөрөнгийн дүн

$$\frac{a}{b} \times 100$$

3.2.5. ХЗХ-ны жилийн тайлант хугацааны эцэс дэх цэвэр орлогоос байгуулах тогтворжилтын сангийн харьцааг Хоршоологчдын өмчийн дүнгээс тооцно.

*Тооцоолол:* а-тайлант хугацааны эцэс дэх тогтворжилтын сангийн дүн  
b-тайлант хугацааны эцэс дэх хоршоологчдын өмчийн дүн

$$\frac{a}{b} \times 100$$

3.2.6. ХЗХ-ны жилийн тайлант хугацааны эцэс дэх цэвэр орлогоос байгуулах хадгаламж хамгаалалтын сангийн харьцааг Хоршоологчдын өмчийн дүнгээс тооцно.

*Тооцоолол:* а-тайлант хугацааны эцэс дэх хадгаламж хамгаалалтын сангийн дүн  
b-тайлант хугацааны эцэс дэх хоршоологчдын өмчийн дүн

$$\frac{a}{b} \times 100$$

3.2.7. ХЗХ-ны жилийн тайлант хугацааны эцэс дэх цэвэр орлогоос байгуулах нөөцийн санг нийт хөрөнгөд харьцуулна.

*Тооцоолол:* а-тайлант хугацааны эцэс дэх нөөцийн сангийн дүн  
b-тайлант хугацааны эцэс дэх нийт хөрөнгийн дүн

$$\frac{a}{b} \times 100$$

3.2.8. Журмын 3.2.5-3.2.7-д заасан сангууд байгуулах харьцаа үзүүлэлтүүдийг жилийн эцсийн санхүүгийн тайланд үндэслэн жилд нэг удаа тооцоолно.

#### **ДӨРӨВ.ӨГӨӨЖ, ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ**

4.1. ХЗХ нь дор дурдсан өгөөж, зардлын харьцаануудыг тооцож, санхүү, төлбөрийн чадвар болон бусад үзүүлэлтэд үнэлгээ, дүгнэлт өгнө.

#### 4.1.1.ХЗХ-ны үйл ажиллагааны зардлыг нийт хөрөнгөд харьцуулна.

*Тооцоолол:* а-тайлант хугацаан дахь үйл ажиллагааны зардлын дүн

б-тайлант хугацааны эцэс дэх нийт хөрөнгийн дүн

$$\frac{a}{b} \times 100$$

4.1.2.Хөрөнгийн өгөөж нь нэг төгрөгөөс ямар хэмжээний орлого олж байгааг харуулах бөгөөд татварын дараах цэвэр орлогыг тайлант хугацааны нийт хөрөнгөд харьцуулан тооцно.

*Тооцоолол:* а-тайлант хугацаан дахь цэвэр орлогын дүн

б-тайлант хугацаан дахь нийт хөрөнгийн дүн

$$\frac{a}{b} \times 100$$

### ТАВ.ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

5.1.Түргэн борлогдох хөрөнгийг мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө, гишүүдээс 30 хоногт эргэн төлөгдөх зээлийн нийлбэрээр тооцно.

5.2.Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг тооцохдоо түргэн борлогдох хөрөнгийг нийт татан төвлөрүүлсэн хадгаламжид харьцуулан тооцно.

*Тооцоолол:* а-тайлант хугацаан дахь түргэн борлогдох хөрөнгийн дүн

б-тайлант хугацаан дахь нийт хадгаламжийн дүн

$$\frac{a}{b} \times 100$$

### ЗУРГАА.БУСАД

6.1.Энэхүү шалгуур үзүүлэлтэд заасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг ханган ажиллаж байгаа эсэхэд ХЗХ-ны бүх гишүүдийн хурал, тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хороо болон гүйцэтгэх удирдлага хууль тогтоомжоор олгогдсон эрхийн хүрээнд хяналт тавьж, хангуулахтай холбоотой зохих арга хэмжээг авч ажиллана.

6.2.ХЗХ зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг дараах хавсралтуудын дагуу улирал бүр тооцож, тайланг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд хүргүүлнэ.

6.2.1.Зээл олголт, эргэн төлөлт, зээлийн зориулалт, хүүгийн судалгааны тайлан (Нэгдүгээр хавсралт);

6.2.2.Хадгаламжийн хүүгийн судалгаа (Хоёрдугаар хавсралт);

6.2.3.40 том зээлдэгчид олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад хөрөнгийн тайлан (Гуравдугаар хавсралт);

6.2.4.Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад хөрөнгийн тайлан (Дөрөвдүгээр хавсралт);

6.2.5.40 том хадгаламж эзэмшигчийн тайлан (Тавдугаар хавсралт);

6.2.6.Их хэмжээний хувь хөрөнгө нийлүүлсэн гишүүдийн тайлан (Зургадугаар хавсралт);

6.2.7.Хөрөнгө, эх үүсвэрийн эргэн төлөгдөх хугацааны тайлан (Долдугаар хавсралт);

6.2.8.Хөрөнгийн чанар болон хамгаалалтын үзүүлэлтийн тайлан (Наймдугаар хавсралт);

- 6.2.9. Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлтийн тайлан (Есдүгээр хавсралт);
  - 6.2.10. Өгөөж, зардлын хувь хэмжээний үзүүлэлтийн тайлан (Аравдугаар хавсралт);
  - 6.2.11. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтийн тайлан (Арван нэгдүгээр хавсралт);
  - 6.2.12. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт (Арван хоёрдугаар хавсралт).
- 6.3. ХЗХ нь Хорооноос шаардсан аливаа мэдээ, судалгааг тухай бүр гаргаж хүргүүлнэ.

“Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”-ийн нэгдүгээр хавсралт

ЗЭЭЛ ОЛГОЛТ, ЭРГЭН ТӨЛӨЛТ, ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ, ХҮҮГИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ЗЭЭЛИЙН АНГИЛАЛ, ЗОРИУЛАЛТ	Мөрийн дугаар	Зээлийн эхний үлдэгдэл				Шинээр олгосон зээл					Төлөлт хийгдсэн зээл				Хаагдсан зээл				Зээлийн эрдэлийн сангаас хаагдсан зээл	Зээлийн эцсийн үлдэгдэл																																	
		Нийт дүн		Үүнээс: Эмэгтэй		Нийт дүн		Үүнээс: Эмэгтэй		Дундаж хугацаа (сараар)	ЖДХүү (сараар)	Нийт дүн		Үүнээс: Эмэгтэй		Нийт дүн		Үүнээс: Эмэгтэй		Дундаж хугацаа (сараар)	ЖДХүү (сараар)	Дэд хүү	Доод хүү																														
1		2		3		4		5				6		7		8		9						10		11		12		13		14		15		16		17		18		19		20		21		22		23		24	
Баганын дугаар																																																					
<b>НИЙТ ДҮН</b>																																																					
Хугацааны ангилал	1																																																				
	2																																																				
	3																																																				
	4																																																				
	5																																																				
	6																																																				
	7																																																				
	8																																																				
	9																																																				
	10																																																				
	11																																																				
Чанарын ангилал	12																																																				
	13																																																				
	14																																																				
	15																																																				
	16																																																				
	17																																																				
18																																																					















4														
5														
6														
7														
8														
9														
10														
Дүн												0.00%	0.00%	
<b>4.Хуулийн этгээд</b>														
1														
2														
3														
4														
5														
6														
7														
8														
9														
10														
Дүн												0.00%	0.00%	
<b>НИЙТ</b>												0.00%	0.00%	
<b>5. Хадгаламж, хугацааны ангиллаар</b>														
30 хоног хүртэл хугацаатай хадгаламж														
1-3 сарын хугацаатай хадгаламж														
3-6 сарын хугацаатай хадгаламж														
6-12 сарын хугацаатай хадгаламж														
1-2 жилийн хугацаатай хадгаламж														
2-5 жилийн хугацаатай хадгаламж														
5-аас дээш жилийн хугацаатай хадгаламж														
<b>НИЙТ</b>												0.00%	0.00%	











28												
29												
30												
31												
32												
33												
34												
35												
36												
37												
38												
39												
40												
БҮГД												

Хамгийн өндөр хадгаламж, бүтээгдэхүүнээр:

Хамгийн өндөр хадгаламж эзэмшигч:

“Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”-ийн зургаадугаар хавсралт

ИХ ХЭМЖЭЭНИЙ ХУВЬ ХӨРӨНГӨ НИЙЛҮҮЛСЭН ГИШҮҮДИЙН ТАЙЛАН

д/д	Хувь хөрөнгө нийлүүлсэн гишүүний нэр	Хүйс	Оруулсан хувь хөрөнгийн тайлант үеийн үлдэгдэл	ХЗХ-ны нийт хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь
1				
2				
3				
4				
5				
6				
7				
8				
9				
10				
11				
12				
13				
14				
15				
16				
17				
18				
19				
20				
21				
22				
23				
24				
25				
26				
27				
28				
29				
30				
31				
32				
33				
34				
35				
36				
37				
38				
39				
40				
БҮГД				

Хамгийн том хувь нийлүүлэгч



“Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”-ийн наймдугаар хавсралт

ХӨРӨНГИЙН ЧАНАРЫН БОЛОН ХАМГААЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТҮҮД						НИЙТ ДҮН	
д/д	Хөрөнгийн ангилал	Зээлийн өрийн үлдэгдэл	Хувь	Эрсдэлийн сангийн хувь	Байгуулбал зохих сан	Байгуулсан сан	Илүү (+), дутуу (-)
<b>A</b>	<b>Нийт зээл</b>	-	<b>100.0%</b>		-		
1	Хэвийн зээл	-	#DIV/0!	0%			
2	Хугацаа хэтэрсэн	-	#DIV/0!	5%			
3	Чанаргүй зээл	-	#DIV/0!				
4	<i>а/Хэвийн бус</i>	-	#DIV/0!	25%			
5	<i>б/Эргэлзээтэй</i>	-	#DIV/0!	50%			
6	<i>в/ Муу</i>	-	#DIV/0!	100%			
<b>B</b>	<b>Нийт ӨБХ</b>	-	<b>100.0%</b>				
1	Хэвийн ӨБХ		#DIV/0!	0%			
2	Хугацаа хэтэрсэн ӨБХ		#DIV/0!	5%			
3	Чанаргүй ӨБХ	-	#DIV/0!				
4	<i>а/Хэвийн бус</i>		#DIV/0!	25%			
5	<i>б/Эргэлзээтэй</i>		#DIV/0!	50%			
6	<i>в/ Муу</i>		#DIV/0!	100%			
<b>B</b>	<b>Нийт авлага</b>	-	<b>100.0%</b>				
1	Хэвийн авлага		#DIV/0!	0%			
2	Хугацаа хэтэрсэн авлага		#DIV/0!	5%			
3	Чанаргүй авлага	-	#DIV/0!				
4	<i>а/Хэвийн бус</i>		#DIV/0!	25%			
5	<i>б/Эргэлзээтэй</i>		#DIV/0!	50%			
6	<i>в/ Муу</i>		#DIV/0!	100%			
<b>ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b>							
<b>I</b>	<b>ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ (5 хувиас хэтрэхгүй)</b>					<b>5.0%</b>	
1	Чанаргүй зээлийн зохистой үзүүлэлт тайлангаар					#DIV/0!	
2	Харьцааны биелэгдээгүй хувь					#DIV/0!	

“Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”-ийн есдүгээр хавсралт

**ҮР АШИГТАЙ САНХҮҮГИЙН БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН**

д/д	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НИЙТ ДҮН
<b>A</b>	<b>ХӨРӨНГӨ</b>	-
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	-
2	Зээл (цэврээр)	-
3	<i>Нийт зээлийн үлдэгдэл - Зээлийн эрсдэлийн сан</i>	-
4	Дансны авлага (цэврээр)	-
5	Өмчлөх бусад санхүүгийн хөрөнгө (цэврээр)	-
6	Бусад санхүүгийн хөрөнгө	-
7	Өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	-
8	Үндсэн хөрөнгө (цэврээр)	-
9	Биет бус хөрөнгө (цэврээр)	-
10	Бусад санхүүгийн бус хөрөнгө	-
<b>Б</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>	-
1	Хадгаламж	-
2	<i>Нийт хадгаламж</i>	-
3	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	-
4	Бусад санхүүгийн өр төлбөр	-
5	Санхүүгийн бус өр төлбөр	-
<b>В</b>	<b>ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>	-
1	Гишүүдийн хувь нийлүүлсэн хөрөнгө	-
2	Өмчийн бусад хэсэг	-
<b>Г</b>	<b>ХОРШООЛОГЧДЫН ӨМЧ</b>	-
1	Нөөцийн сан	-
2	Тогтворжилтын сан	-
3	Хадгаламж хамгаалалтын сан	-
4	Нийгмийн хөгжлийн сан	-
5	Бусад сан	-
6	Хуримтлагдсан орлого/алдагдал	-
	<b>ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ХӨРӨНГӨД ЭЗЛЭХ ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ (60-85 хувь)</b>	<b>60-85%</b>
1	Харьцаа тайлангаар	#DIV/0!
2	Харьцааны биелэгдээгүй хувь	#DIV/0!
<b>II</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (10 хувиас хэтрэхгүй)</b>	<b>10.0%</b>
1	Харьцаа тайлангаар	#DIV/0!
2	Харьцааны биелэгдээгүй хувь	#DIV/0!
<b>III</b>	<b>ГИШҮҮДИЙН ХАДГАЛАМЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (40-80 хувь)</b>	<b>40-80%</b>
1	Харьцаа тайлангаар	#DIV/0!
2	Харьцааны биелэгдээгүй хувь	#DIV/0!
<b>IV</b>	<b>БУСДААС АВСАН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (20 хувиас хэтрэхгүй)</b>	<b>20.0%</b>
1	Харьцаа тайлангаар	#DIV/0!
2	Харьцааны биелэгдээгүй хувь	#DIV/0!
<b>V</b>	<b>НЭГ ГИШҮҮНИЙ ОРУУЛЖ БОЛОХ ХУВЬ ХӨРӨНГӨ (10 хувиас хэтрэхгүй)</b>	<b>10.0%</b>
1	Харьцаа тайлангаар	#DIV/0!
2	Харьцааны биелэгдээгүй хувь	#DIV/0!
<b>VI</b>	<b>НӨӨЦИЙН САНГИЙН ХЭМЖЭЭ (3.0 хувиас доошгүй)</b>	<b>3.0%</b>

1	Харьцаа тайлангаар	#DIV/0!
2	Харьцааны биелэгдээгүй хувь	#DIV/0!
<b>VII</b>	<b>ХОРШООЛОГЧДЫН ӨМЧИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас доошгүй)</b>	<b>5.0%</b>
1	Харьцаа тайлангаар	#DIV/0!
2	Харьцааны биелэгдээгүй хувь	#DIV/0!
<b>VIII</b>	<b>ХАДГАЛАМЖ ХАМГААЛАЛТЫН САНГИЙН ХЭМЖЭЭ (5 хувиас доошгүй)</b>	<b>5.0%</b>
1	Харьцаа тайлангаар	#DIV/0!
2	Харьцааны биелэгдээгүй хувь	#DIV/0!
<b>IX</b>	<b>ТОГТВОРЖИЛТЫН САНГИЙН ХЭМЖЭЭ (5 хувиас доошгүй)</b>	<b>5.0%</b>
1	Харьцаа тайлангаар	#DIV/0!
2	Харьцааны биелэгдээгүй хувь	#DIV/0!

“Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”-ийн аравдугаар хавсралт

**ӨГӨӨЖ, ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН**

д/д	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Нийт дүн
<b>A</b>	<b>Хүүгийн цэвэр орлого (A1-A2)</b>	-
1	Хүүгийн орлого	-
2	Хүүгийн зардал	-
<b>B</b>	<b>Хүүгийн бус орлого</b>	-
<b>B</b>	<b>Хүүгийн бус зардал</b>	-
<b>Г</b>	<b>Татварын дараах цэвэр орлого</b>	-
<b>Д</b>	<b>Үйл ажиллагааны зардал</b>	-
<b>Е</b>	<b>Нийт хөрөнгө</b>	-
<b>Ё</b>	<b>Эрсдэлийн сангийн зардал</b>	-
<b>Ж</b>	<b>Зээлийн эрсдэлийн сан</b>	-
<b>З</b>	<b>Нийт хүүгийн орлого оруулдаг хөрөнгө</b>	-
<b>И</b>	<b>Хувь нийлүүлсэн хөрөнгө</b>	-
<b>Й</b>	<b>Нийт зээл</b>	-
<b>ӨГӨӨЖ, ЗАРДЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b>		
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ТҮВШИН (10 хувиас хэтрэхгүй)</b>	<b>10.0%</b>
1	Харьцаа тайлангаар	#DIV/0!
2	Харьцааны биелэгдээгүй хувь	#DIV/0!
<b>II</b>	<b>ӨГӨӨЖ</b>	
1	Хөрөнгийн өгөөж	#DIV/0!
<b>III</b>	<b>Хүүгийн орлого / Нийт хөрөнгө</b>	<b>#DIV/0!</b>
<b>IV</b>	<b>Хүүгийн зардал / Нийт хөрөнгө</b>	<b>#DIV/0!</b>
<b>V</b>	<b>Хүүгийн цэвэр орлого / Нийт хөрөнгө</b>	<b>#DIV/0!</b>
<b>VI</b>	<b>Хүүгийн бус орлого / Нийт хөрөнгө</b>	<b>#DIV/0!</b>
<b>VII</b>	<b>Хүүгийн бус зардал / Нийт хөрөнгө</b>	<b>#DIV/0!</b>
<b>VIII</b>	<b>Эрсдэлийн сангийн зардал / Нийт хөрөнгө</b>	<b>#DIV/0!</b>
<b>IX</b>	<b>Хүүгийн орлого / Хүүгийн орлого оруулдаг хөрөнгө</b>	<b>#DIV/0!</b>
<b>X</b>	<b>Зээлийн эрсдэлийн сан / Нийт зээлийн өрийн үлдэгдэл</b>	<b>#DIV/0!</b>

“Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”-ийн арван нэгдүгээр хавсралт

ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН

д/д	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Нийт дүн
<b>A</b>	<b>ТҮРГЭН БОРЛОГДОХ ХӨРӨНГӨ</b>	-
1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	-
2	Зээл (30 хоногт төлөгдөх зээл)	-
<b>B</b>	<b>ГИШҮҮДИЙН НИЙТ ХАДГАЛАМЖ</b>	-
1	Хугацаагүй хадгаламж	-
2	Хугацаатай хадгаламж	-
	<b>ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b>	
<b>B</b>	<b>ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА (10 хувиас дээш)</b>	<b>10.0%</b>
1	Зохистой харьцаа тайлангаар А/Б	#DIV/0!
2	Харьцааны биелэгдээгүй хувь (B1-B)	#DIV/0!

“Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”-ийн арван хоёрдугаар хавсралт

**ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

д/д	ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	ТАЙЛАНГААР
<b>А</b>	<b>ХӨРӨНГИЙН ЧАНАР БОЛОН ХАМГААЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ</b>		
1	ХӨРӨНГӨ (АКТИВ)-ИЙН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ (+ илүү, -дутуу)	-	-
2	ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	5%-аас хэтрэхгүй	#DIV/0!
3	НЭГ ГИШҮҮНД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	30%-аас хэтрэхгүй	#DIV/0!
4	НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	30%-аас хэтрэхгүй	#DIV/0!
<b>Б</b>	<b>ҮР АШИГТАЙ САНХҮҮГИЙН БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ</b>		
1	НИЙТ ХӨРӨНГӨ (АКТИВ)-Д ЭЗЛЭХ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	60%-85%	#DIV/0!
2	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	10%-аас хэтрэхгүй	#DIV/0!
3	ГИШҮҮДИЙН ХАДГАЛАМЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	40%-80%	#DIV/0!
4	БУСДААС АВСАН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	20%-аас хэтрэхгүй	#DIV/0!
5	НЭГ ГИШҮҮНИЙ ОРУУЛЖ БОЛОХ ХУВЬ ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	10%-аас хэтрэхгүй	#DIV/0!
6	ХОРШООЛОГЧДЫН ӨМЧИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	5%-аас доошгүй	#DIV/0!
7	НӨӨЦИЙН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ	-	-
8	ХАДГАЛАМЖ ХАМГААЛАЛТЫН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ	-	-
9	ТОГТВОРЖИЛТЫН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ	-	-
<b>В</b>	<b>ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХЭМЖЭЭ</b>		
10	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	10%-аас хэтрэхгүй	#DIV/0!
<b>Г</b>	<b>ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР</b>		
11	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	10%-аас доошгүй	#DIV/0!
<b>Д</b>	<b>ӨГӨӨЖ, ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭ (ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ)</b>		
12	ХӨРӨНГӨ /АКТИВ/-ИЙН ӨГӨӨЖ		#DIV/0!

*ХЗХ нь Хорооноос тусгай зөвшөөрөл олгосноос хойш 4 улиралд багтаан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажиллах үүргийг хүлээнэ.*